


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 4 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.04.20

Газрын удирдлагын хэлтэс:

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл:

Аймгийн ИТХ-д тариалангийн бүс нутаг тогтоох асуудлыг хэлэлцүүлэхээр хүсэлт гарган 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Тариалангийн бүс нутаг тогтоох тухай” 06 дугаар тогтоолоор тариалангийн бүс нутгийн хил заагийг тогтоон солбицолжуулан баталлаа. Уг тогтоолыг 3 сумдын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлэв.



Нийт 4 байршилд 10928 га газар

№	Аймгийн нэр	Сумын нэр	Газрын нэр	гр			мин			Талбайн хэмжээ (га)
				гр	мин	сек	гр	мин	сек	
1.	Говьсүмбэр	Сүмбэр	5, 6-р баг Уул худаг	108° 1'	6.713"	46"	30	58.058"	10000	
				108° 0'	54.911"	46"	36	21.844"		
				108° 53'	5.142"	46"	36	13.423"		
				108° 53'	17.718"	46"	36	49.893"		
2.	Говьсүмбэр	Сүмбэр	4-р баг Таш	108° 25'	10.475"	46"	17	39.845"	520	
				108° 26'	41.945"	46"	17	58.362"		
				108° 27'	16.929"	46"	17	27.423"		
				108° 27'	38.871"	46"	17	0.864"		
3.	Говьсүмбэр	Сүмбэр	4-р баг Шивээгийн булаг	108° 26'	17.732"	46"	16	18.911"	250	
				108° 27'	26.600"	46"	13	46.224"		
				108° 26'	21.287"	46"	14	16.585"		
				108° 26'	2.775"	46"	13	39.286"		
4.	Говьсүмбэр	Шивээговь	2-р баг Шивээгийн булаг	108° 28'	25.151"	46"	12	57.800"	158	
				108° 28'	45.123"	46"	12	36.029"		
				108° 29'	38.188"	46"	12	44.472"		
				108° 30'	6.725"	46"	13	13.837"		
Бүгд				108° 30'	22.950"	46"	13	2.500"	10928	
108° 29'	35.581"	46"	12	24.124"						
108° 28'	54.543"	46"	12	13.218"						



Аймгийн Засаг даргын захирамжаар:

- Газар эзэмших эрхийг дуусгавар болгох тухай-2;
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай-1;
- Газар эзэмшүүлэх эрхийг шилжүүлэх-4;
- Газар эзэмшүүлэх тухай-1;
- газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах тухай-1 тус тус шийдвэр гараад байна.

Газрын төлбөр, татварын талаар:


Газрын төлбөрийн орлогоор 2017 онд 90 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 33,5 сая төгрөгийг төвлөрүүлж, төлбөрийн төлөвлөгөө 37,2 хувийн биелэлттэй байна.

Газар хэмжүүлэх хүсэлт гаргасан ИААНБ-ын нийт өссөн дүнгээр 19 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. 100220029002 тоот дансанд 624900 төгрөгийг төвлөрүүлж, 12 иргэн аж ахуйн нэгж байгууллагын эргэлтийн цэгийн газар дээр тэмдэгжүүлж актаар хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн хэмжээний тариалангийн талбайн газруудын эргэлтийн цэгийн газар дээр тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:

Шивээговь суманд 3 иргэний 10 эргэлтийн цэг, Сүмбэр суманд 2 иргэний 8 эргэлтийн цэг, 2 аж ахуйн нэгж байгууллагын 14 цэгийг тус тус газар дээр нь бэхлэж тэмдэгжүүлсэн байна.

Чойрын богд уул орчмын аялал жуулчлалын зориулалттай 10 газрын дэвсгэр зургийн хэмжилтийг хийсэн байна. Одоогийн байдлаар суурин боловсруулалтын ажилд бэлтгэж байна.



Сургалтын талаар:

2017 оны 05 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Зүүн бүсийн сургалтыг Дорнод аймаг зохион байгууллаа. Сургалтанд Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, газрын даамлууд нийт 80 хүн оролцов. Манай аймгаас ГХБХБГ-ын мэргэжилтэн, 3 сумын газрын даамлыг оролцон тулгамдаж буй бэрхшээлийн хэлэлцүүлэг, болон холбогдох бүлгийн сургалтанд чиглэлийн дагуу хамрагдав.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Захиалагчийн техник хяналт:

1. Сүмбэр сум 5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны засварын ажил
2. Сүмбэр сум 5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны гадна тохижилтын ажил
3. Баянтал сум 4 дүгээр сургуулийн дотуур байрны засвар
4. Баянтал сум 4 дүгээр сургуулийн спорт заалны цахилгаан хангамж монтажны ажил


5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны засварын ажлын гүйцэтгэл 98% хувьтай хийгдсэн байна.



5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны гадна тохижилт 2016-2017 хэрэгжиж байгаа ажлын гүйцэтгэл 80 хувьтай хийгдсэн байна.



Баянтал сум 4 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажлын гүйцэтгэл 100 хувьтай ажил дуусч дотоодын хяналт шалгалтын баг ажилласан.



Баянтал сум 4 дүгээр сургуулийн спорт заалны цахилгаан хангамж монтажны ажлын гүйцэтгэл 100 хувьтай ажил дуусч дотоодын хяналт шалгалтын баг ажилласан.



Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байдал:

1. Баянтал сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны цахилгаан хангамж монтажны ажил 2017.04.18-2017.04.24 хүртэл

Барилгын материалын чиглэлээр:

Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөрийн хүрээнд байгууллагын дотоод нөөц бололцоогоор ГХБХБГ-ын дэргэдэх барилгын материалын лабораторийн барилгын ажлын зураг төсвийг зураг төсвийн “Ориентплюс” ХХК-иар боловсруулаад байна. Ажлын зургийн дагуу 2017 онд лабораторийн барилгыг үе шаттайгаар гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Аймгийн хэмжээнд барилгын материал тогтмол болоод улирлын чанартай үйлдвэрлэл эрхэлж байгаа “ОСО констракшн” ХХК, “Илчит сансар” ХХК-дад хагас бүтэн жилээр үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чанарт хяналт тавих зорилгоор үйлдвэрт очиж хяналтын ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хот байгуулалтын чиглэлээр:

Газар хөдлөлт гамшгаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар удирдуулсан комисс манай аймагт 2017 оны 05 дугаар сарын 19-ны өдөр ажиллаж газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжид хамрагдаж байгаа сургууль, эмнэлэгийн барилга байгууламжаар орж ажиллаа. Тус бүрэлдэхүүнд аймгийн гамшгаас сэргийлэх байнгын ажиллагаантай зөвлөлийн гишүүн ГХБХБГ-ын Д.Тамир, БХБХ-ийн дарга Б.Даваажаргал нар оролцож цаг үеийн мэдээ мэдээллийг солилцлоо.

Сургалт:

2017 оны 05 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд Зүүн бүсийн 7 аймгийн Газрын харилцаа Барилга хот байгуулалтын газруудын сургалт, зөвлөгөөн Дорнод аймгийн Чойбалсан хотод болж амжилттай оролцсон.